



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2016-2020 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД 2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН
/ЗТХЯ-ны хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээ/

2017.12.29

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээний зорилго, үндэслэл, арга зүй

Хяналт-шинжилгээ хийх зорилго нь Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хангахад чиглэгдсэн арга хэмжээний гүйцэтгэлийн явцын талаар дүгнэлт гаргаж, холбогдох байгууллага, албан тушаалтанд бодит мэдээлэл өгсний үндсэн дээр төлөвлөсөн арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэх зохион байгуулалт, зохицуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Эрх зүйн үндэслэл нь “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоол, “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоол, “Ажил хариуцуулж, хэрэгжүүлэх тухай” Зам, тээврийн хөгжлийн яамны ТНБД-ын 2017 оны 59 дүгээр тушаал болно. Эдгээр тогтоол, тушаалын заалтын дагуу хэрэгжүүлсэн ажлын явцад хийсэн хяналт-шинжилгээний тайлан, төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний биелэлтийн хамт Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэх ба энэ нь Засгийн газраас тус яамны үйл ажиллагааг үнэлж дүгнэх нэг шалгуур үзүүлэлт болохын зэрэгцээ яамны ерөнхий менежер, нэгжийн менежерүүдийн үйл ажиллагаа, үр дүнгийн гэрээний биелэлтийн түвшинг үнэлж, дүгнэх нэг үзүүлэлт болох ач холбогдолтой.

Арга хэмжээ тус бүрийн гүйцэтгэлийн түвшингийн хувийг тогтооходоо Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”-ыг баримталсан болно.

Хоёр. Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн байдал

Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоолоор баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Зам, тээврийн хөгжлийн сайдын “үндсэн хэрэгжүүлэгч байгууллага” буюу дангаар болон толгойлон хэрэгжүүлэх 117 арга хэмжээн дээр “МТЗ” ТӨХК-ийн толгойлон хэрэгжүүлэх 5, “УБТЗ” ХНН-ийн толгойлон хэрэгжүүлэх 3, Концесс эзэмшигч “Нортерн рейлвейс” ХХК-ийн толгойлон хэрэгжүүлэх 1 арга хэмжээг нэмж, нийт 126, бусад байгууллага, Засгийн газрын гишүүдтэй хамтран хэрэгжүүлэх 20, оролцон хэрэгжүүлэх 1 арга хэмжээ, нийт 147 арга хэмжээ тусгагдсан.

Зам, тээврийн хөгжлийн сайдын үндсэн хэрэгжүүлэх 126 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж дуусгах хугацаагаар нь ангилж үзүүлбэл:

Хүснэгт 1

2016 -2020	2017 он	2018 он	2019 он	2020 он
	2.107.14, 2.107.15, 2.107.32, 2.109.2, 2.114.8, 2.114.9, 2.114.14, 2.114.16,	2.107.1, 2.107.4, 2.107.13, 2.107.16, 2.107.18, 2.107.23, 2.108.1, 2.111.1, 2.113.3, 2.114.5, 2.114.15, 2.115.4, 2.118.3,	2.107.5, 2.107.6, 2.107.7, 2.107.24, 2.107.27, 2.107.28, 2.107.30, 2.113.2, 2.114.7, 2.114.13, 2.119.3, 2.119.4, 3.2.33.6, 6.11.1.1, 6.13.1.1, 6.14.2.2,	2.11.2, 2.107.2, 2.107.3, 2.107.8, 2.107.9, 2.107.10, 2.107.11, 2.107.12, 2.107.17, 2.107.19, 2.107.20, 2.107.21, 2.107.22, 2.107.25, 2.107.26, 2.107.29, 2.107.31, 2.107.33, 2.107.34, 2.107.35, 2.108.2, 2.109.1, 2.110.1, 2.111.2, 2.111.3, 2.111.4, 2.112.1,



	2.116.2, 2.118.6, 6.4.1.1, 6.19.2.2	2.118.4, 6.2.1.1, 6.3.1.1, 6.8.2.1, 6.9.1.1, 6.9.1.2, 6.9.1.3, 6.9.1.4, 6.16.1.1, 6.16.1.2, 6.16.1.3, 6.19.1.1, 6.19.3.3,	6.16.1.4, 6.21.1.1	2.113.1, 2.114.1, 2.114.2, 2.114.3, 2.114.4, 2.114.6, 2.114.10, 2.114.11, 2.114.12, 2.114.17, 2.115.1, 2.115.2, 2.115.3, 2.116.1, 2.117.1, 2.117.2, 2.117.3, 2.117.4, 2.118.1, 2.118.2, 2.118.5, 2.118.7, 2.119.1, 2.119.2, 2.120.1, 2.121.1, 2.121.2, 2.121.3, 2.121.4, 3.2.33.7, 4.1.3.6, 4.4.5.2, 5.1.3.1, 5.6.1.5, 5.6.1.6, 5.6.5.2, 6.1.1.1, 6.7.1.1, 6.8.1.1, 6.14.1.1, 6.16.1.5, 6.16.1.6, 6.16.1.7,
126	12	26	18	70

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 онд үндсэн хэрэгжүүлэх 95 арга хэмжээний биелэлтийг жилийн эцсийн байдлаар үнэллээ. Хэрэгжилт **дунджаар 79.4%** хувьтай байна.


Төлөвлөгөөнд туссан арга хэмжээг яамны газар, хэлтэс, байгууллагын хариуцсан асуудал тус бүрээр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

Хүснэгт 2

Үнэлгээ	БТГ	ТЗДТБХЗГ	АЗБХЗГ	АТБХЗГ	АТБХЗХ	“МТЗ” ТӨХК	“УБТЗ” ХНН	Концесс эзэмшигч “Нортерн рэйлвейс” ХХК	Далайн захиргаа	НИЙТ
100%	2.113.2, 2.113.3, 2.118.7, 3.2.33.7	2.111.2, 2.111.4, 2.113.2, 2.113.3, 2.117.1, 2.117.3, 2.117.4, 2.118.1, 5.6.1.5	2.107.1, 2.107.14, 2.107.18, 2.107.22, 2.107.32, 2.113.2, 2.113.3, 2.121.1, 2.121.2, 6.14.1.1	2.113.2, 2.113.3, 2.118.4, 2.120.1	2.113.3, 2.114.1, 2.114.3, 2.114.4, 2.114.5, 2.114.6, 2.114.8, 2.114.13, 2.114.16, 2.114.17, 2.115.1, 2.115.3, 2.115.4		2.111.2 2.118.1		2.117.1, 2.117.3, 2.117.4	
	4	9	10	4	13	-	2	-	3	33
70%	2.118.3, 3.2.33.6, 4.1.3.1, 5.6.1.6	2.108.1, 2.108.2, 2.110.1, 2.111.1, 2.112.1, 2.117.2, 5.6.1.6	2.107.4, 2.107.16, 2.107.23, 2.119.4, 2.121.4, 4.4.5.2, 5.6.1.6, 6.11.1.1, 6.19.2.2	2.116.2, 2.118.2, 2.118.5, 2.118.6, 4.4.5.2, 5.6.1.6	2.114.9, 2.114.10, 2.114.14	2.108.1, 2.108.2, 2.110.1	2.111.1	2.112.1		
	4	7	9	6	3	3	1	1	-	26
40%	5.1.3.1, 5.6.5.1	2.109.2, 2.111.3, 5.1.3.1,	2.107.15, 2.119.3, 5.1.3.1, 6.3.1.1	2.116.1, 5.1.3.1,	2.114.11, 2.114.12, 2.115.2, 5.1.3.1, 6.19.3.3	2.109.2			2.117.2	
	2	3	4	2	5	1	-	-	1	11
0%	-	-	-	-	-	-	-	-	-	-
Үнэлэх боломжгүй	2,11,2, 2,113.1	2,113.1	2.107.5, 2.113.1, 2.121.3, 6.1.1.1, 6.4.1.1, 6.7.1.1, 6.8.1.1, 6.9.1.1, 6.9.1.2, 6.9.1.3, 6.9.1.4, 6.13.1.1, 6.14.2.2, 6.16.1.1, 6.16.1.2, 6.16.1.3, 6.16.1.6, 6.16.1.7, 6.19.1.1, 6.21.1.1	2,113.1	2,113.1, 2,114.2, 2,114.7, 2,114.15, 6.2.1.1					
	2	1	20	1	5	-	-	-	-	25
Нийт	12	20	43	13	26	4	3	1	4	95
	76%	79.5%	74.8%	75%	80%	62.5%	90%	70%	85%	79.4%


Нийт арга хэмжээний хэрэгжилтийг газар, хэлтэс, байгууллага тус бүрээр ангилж үзүүлбэл:

Зураг 1



Нийт арга хэмжээг хэрэгжилтийн хувиар үзүүлбэл:

Зураг 2



Засгийн газрын гишүүдтэй хамтран хэрэгжүүлэх 20 зорилт, арга хэмжээг хэрэгжүүлж дуусгах хугацаагаар нь ангилж үзүүлбэл:

Хүснэгт 3

	2016 -2020	2017 он	2018 он	2019 он	2020 он
Хамтран хэрэгжүүлэх	20	2.95.1	2.85.3	2.85.4, 2.100.1	2.11.1, 2.113, 2.48.6, 2.48.7, 2.58.2, 2.65.2, 2.100.3, 2.119.5, 3.110.10, 3.2.33.5, 3.3.28.5, 3.3.29.1, 3.4.6.1, 3.4.6.2, 4.4.5.1, 5.6.1.4
		1	1	2	16
Оролцон хэрэгжүүлэх	1				3.2.28.4
		-	-	-	1



Засгийн газрын гишүүдтэй 2017 онд хамтран хэрэгжүүлэх 18 арга хэмжээний биелэлтийг жилийн эцсийн байдлаар үнэллээ. Хэрэгжилт **дунджаар 70%** хувьтай байна. Үүнд:

Хүснэгт 4

Хариуцах байгууллага	Нийт заалт	100	70	40	0	Үнэлэх боломжгүй	Хувь
ЗТХЯ	18	3	11	3	-	1	70

Гурав. Дүгнэлт

1. Хэрэгжилтийн хувьд авч үзвэл 2017 оны жилийн эцсийн байдлаар үр дүнтэй буюу 100 хувийн хэрэгжилттэй 33, тодорхой үр дүнд хүрсэн буюу 70 хувийн хэрэгжилттэй 26, эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувийн хэрэгжилттэй 11, үнэлэх боломжгүй 25 арга хэмжээ байна.

Аймаг, орон нутагт хэрэгжүүлэх 17 арга хэмжээний хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй, ЗГ-ын 2016 оны 63 дугаар тэмдэглэлээр эдийн засгийн хүндрэлтэй байгаа нөхцөл байдалтай уялдуулан төсөвт ирэх ачааллыг бууруулах зорилгоор улсын хөгжлийн төлөвлөлттэй нийцээгүй, нийгэм эдийн засгийн ач холбогдол багатай авто замын барилгын ажлыг хийж гүйцэтгэх хугацааг түр хойшлуулахаар шийдвэрлэсэн тул хэрэгжих боломжгүй байна.

2. Дараах шалтгааны улмаас доорх 25 арга хэмжээг үнэлэх боломжгүй гэж үзлээ. Үүнд:

Хүснэгт 5

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт
2.11.2	“Эдийн засгийн коридор” хөтөлбөрийн хүрээнд 3 улсын хил дамнасан олон улсын авто замын транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг судлан шийдвэрлүүлэх /Логистик хөгжих нөхцөл бүрдэх/	Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах чиглэлээр судалгаа хийж зураглал гарган, ажлын даалгавар боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг ЗТХ-ийн сайдын 2017 оны 58 дугаар тушаалаар байгуулсан. Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгааны ажлыг 2017 онд 25.0 сая төгрөгөөр хийхээр зам, тээврийн салбарын норм нормативыг боловсронгуй болгох сангийн 2017-2018 оны төлөвлөгөөнд тусгасан. Уг ажлын хүрээнд ачаа тээврийн хэмжээ, хэтийн төлөвийг судлан, ачаа үүсэх, шингээх гол цэгүүдийг тодорхойлон, замын сүлжээтэй уялдуулан тээвэр логистикийн төвүүдийн байршлыг тодорхойлох ажлыг хийхээр төлөвлөсөн. “Үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулах судалгаа”-ны ажлын даалгаварт 3 улсын хил дамнасан олон улсын авто замын транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг тусгаж, 2017 оны 06 дугаар сард ТНБД-аар батлуулсан. Уг судалгааны ажлыг салбарын нормчлолын сангийн хөрөнгөөр санхүүжүүлж, “Монголын логистикийн холбоо” ТББ хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. 2018 оны 04 дүгээр сард дуусна. Худалдаа-Эдийн засаг, Шинжлэх ухаан-Техникийн Хамтын Ажиллагааны Монгол улс, ОХУ-ын Засгийн газар хоорондын Тээврийн ажлын хэсгийн 13-р хуралдаанаар “Эдийн засгийн коридор” хөтөлбөрийн хүрээнд 3 улсын хил дамнасан олон улсын авто замын транзит тээвэрлэлтийн тодорхой хэсгийг Алтанбулаг чөлөөт бүсээр дамжин өнгөрүүлэх асуудлыг тавьсан боловч тодорхой шийдвэрт хүрч чадаагүй болно.
2.107.5	Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто	Концессын гэрээгээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгүүлэх концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан авто замын барилгын ажлуудын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, гэрээний хэрэгжилтийг зохицуулахтай холбоотой асуудлыг чиг үүргийн дагуу Аж,

	<p>замыг барих</p> <p>/Барилгын ажлын гүйцэтгэл 20 хувь/</p>	<p>үйлдвэрийн яам /хуучнаар/ болон Хөрөнгө, оруулалтын газар /хуучнаар/ хариуцан ажиллаж байсан бөгөөд Засгийн газрын 2015 оны 87 дугаар тогтоолоор Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замыг барих шилжүүлэх нөхцөлтэйгээр “Эрчим хүчний барилга угсралтын трест” ХХК-тай 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдөр концессын гэрээ байгуулан барилгын ажлыг эхлүүлсэн. Гүйцэтгэгч компани нь 2015 онд уг замын трасс сэргээх, хөрс хуулах зэрэг бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд одоогоор НИЙТ АЖЛЫН ЯВЦ 5%-ТАЙ байна. Гэрээний дагуу уг авто замыг 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр ашиглалтад оруулахаар ажиллаж байсан хэдий ч өмнө нь гэрээ байгуулж байсан “Эрдэнэ зам” ХХК-ийн зүгээс нэхэмжлэл гаргаж, МУ-ын Засгийн газрыг шүүхэд өгснөөр төслийн ажлыг шүүхээс түр зогсоогоод байна. ЗГ-ын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 63 дугаар тэмдэглэлээр барилга угсралтын ажил нь шүүхийн маргааны улмаас түр зогссон аймгийн төвийг нийслэлтэй холбох зорилтын хүрээнд хэрэгжиж буй Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг гүйцэтгүүлэх концессын гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах тухай шүүхийн маргаан шийдвэрлэгдсэний дараагаар хөрөнгийн өөр эх үүсвэрээс төслийг хэрэгжүүлэх талаар зохих арга хэмжээг авахаар шийдвэрлэсэн. ЗГ-ын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн хуралдааны 13-р тэмдэглэлээр Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км авто замын барилгын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан аж ахуйн нэгжтэй үүссэн шүүхийн маргааныг эцэслэн шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг сайд Д.Ганбатад, тус авто замын төслийн ажлыг шууд гэрээ байгуулан эхлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг ҮХГ-ын дарга Б.Баярсайханд даалгасан. Өгсөн үүрэг даалгаврын дагуу “Эрдэнэ зам” ХХК болон “Эрчим хүчний барилга угсралтын трест” ХХК-иудын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж саналыг нь авсан. Уулзалтаар тохиролцсоны дагуу ТНБД-ын 2017 оны 164 дүгээр тушаалаар тус чиглэлийн замд хийгдсэн ажлын тоо хэмжээг тодорхойлж, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг 2017.06.06-10-ны өдрүүдэд зам барилгын ажлын талбайд ажиллаж, хэмжилт хийсэн. 2017.06.12-ны өдөр ажлын хэсэг хуралдаж, дүгнэлтийг 2017 оны 03/2674 тоот албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт, 06/2675 тоот албан бичгээр “Эрчим хүчний барилга угсралтын трест” ХХК болон “Аварга зам” ХХК-иудад тус тус хүргүүлсэн. “Эрдэнэ зам” ХХК шүүхээс нэхэмжлэлээ татан авснаар 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 181/ШЗ2017/09403 захирамж гарч, шүүхийн маргаан дуусгавар болсон тул концесс эзэмшигч “Эрчим хүчний барилга угсралтын трест” ХХК-иас зам барилгын ажлаа үргэлжлүүлэх хүсэлт гаргасны дагуу Үндэсний хөгжлийн газраас концессын гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах урьдчилсан нөхцөлүүдийг хангах үүрэг даалгавар өгсөн байна. Концесс эзэмшигчийн зүгээс урьдчилсан нөхцөл хангах ажил хийж байна.</p>
<p>2.113.1</p>	<p>Хөшигийн хөндийд тээвэр логистикийн төв байгуулах</p> <p>/ТЭЗҮ-ийг боловсруулах/</p>	<p>Хөшигийн хөндийд тээвэр логистикийн төв байгуулах ажлын даалгавар боловсруулах, судлах үүрэг бүхий ажлын хэсгийг ЗТХ-ийн сайдын 2017 оны 58 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг ажлын даалгаврыг боловсруулж ЗТХЯ-ны ТНБД-аар батлуулсан.</p> <p>Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг даган хөгжих шинэ хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний тодотгол боловсруулах ажлын даалгаврын төсөлд Хөшигийн хөндийд олон улсын ачаа тээврийн ложистик төв, зорчигч тээврийн терминалыг барих, тээврийн хэрэгслийн нэгдсэн авто зогсоолыг төлөвлөх санал хүргүүлсэн. “Логистикийн салбарын чадавхийг бэхжүүлэх техникийн туслалцаа CDТА 8080 MON төсөл”-ийг хэрэгжүүлж буй КРМГ компанийн явцын болон эцсийн тайлантай танилцаж санал, зөвлөмж, үйл ажиллагааны чиглэл өгч ажилласан. Хөшигийн хөндийн шинэ нисэх онгоцны буудалтай уялдуулан Улаанбаатар логистикийн төвийг байгуулах судалгаа хийгдсэн. Эцсийн тайланг ЗТХЯ-нд ирүүлээд байна. Тайланг хүлээн авч баталгаажуулахаар ажиллаж байна.</p>

		<p>Улаанбаатар хотын ОУШНБ-ын Ашиглалтын өмнөх захиргааны албанаас гаргасан “Ачаа, тээврийн судалгаа”-нд далайд гарцгүй манай орны хувьд дотоодын логистикийн салбарыг хөгжүүлэх нь улсын эдийн засагт онцгой ач холбогдолтой гэж дүгнэсэн бөгөөд тус алба нь газар зүйн байршлын давуу талыг ашиглан Монгол Улсыг тив дамнасан зорчигч болон ачаа тээврийн дамжин өнгөрөх зангилаа болгох боломжийг нарийвчлан судалж байна.</p> <p>Хөшгийн хөндийн тээврийн логистикийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулах хөрөнгийн асуудал шийдвэрлэх ажлын хүрээнд МУ-ын Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтад танилцуулга хүргүүлээд байна. АХБ-ны холбогдох мэргэжилтэнтэй 2017 оны 03 дугаар сарын 16-ны өдөр уулзалт хийж, энэхүү асуудлыг танилцуулсан боловч АХБ-ны 2017 онд санхүүжүүлэх төслийн жагсаалтад Хөшгийн хөндийн тээвэр логистикийн төв байгуулах ТЭЗҮ боловсруулах асуудал тусгагдаагүй тухай мэдэгдсэн.</p> <p>Богдхан төмөр замын чигийн судалгаа 2017 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс АХБ-ны техникийн туслалцаагаар эхлээд байна. Энэ ажил хийгдсэний дараа Хөшгийн хөндийн тээврийн логистикийн төв байгуулах байршил, ТЭЗҮ хийх үндэслэл бүрдэнэ.</p> <p>Монгол Улсын 2018-2021 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөлд Хөшигийн хөндийн холимог тээврийн логистикийн төв байгуулах санал тусгасан.</p>
2.114.2	Орон нутгийн нислэгийг сэргээн тогтворжуулахад агаарын тээврийн компаниудыг татварын бодлогоор дэмжих /-/	<p>ЗТХ-ийн сайдын 2016 оны 93 дугаар тушаалаар Орон нутгийн агаарын тээврийг сэргээн тогтворжуулах, агаарын тээврийн үнэ тарифыг бууруулах талаар судалгаа хийж санал боловсруулах, дүгнэлт гаргах ажлын хэсгийг томилон ажиллуулж байна. Орон нутгийн хуваарьт нислэгийн үйлчилгээ болон орон нутгийн нисэх буудлын үйлчилгээнд нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хувиар тогтоолгох эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх зорилгоор холбогдох хуулийн төсөл, үзэл баримтлал, танилцуулгыг боловсруулан Сайдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон боловч Монгол Улс ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-т хамрагдсантай холбогдуулан асуудлыг түр хойшлуулсан.</p> <p>Аймгууд руу тогтмол нислэг хийх асуудлыг шийдвэрлүүлэхээр Сангийн яаманд ЗТХ-ийн сайдын 2017 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 01/4689 тоот албан бичгийг хүргүүлсэн.</p> <p>Сангийн яамны 2017 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 4-3/6325 тоот албан бичгээр дотоодын агаарын тээвэрлэгчдийн нислэгийн татаасыг нэг удаагийн нислэгийн суудал дүүргэлтийн 30% хүртэлх хэмжээнд дүйцүүлж нөхөн олговортой нислэгийг гүйцэтгүүлэхийг дэмжиж, тус агаарын тээвэрлэгчдийн ИНЕГ-т төлөх өр төлбөрөөс хасах замаар шийдвэрлэх чиглэл өгсөн. Нөхөн олговортой нислэгийн гүйцэтгүүлэх уралдаант шалгаруулалт зарлах бэлтгэл ажлыг хангасан. Улаанбаатар-Алтай чиглэлд Агаарын тээвэрлэгчдийн ИНЕГ-т төлөх өр төлбөрөөс суутгах зарчмаар нөхөн олговортой нислэгийг гүйцэтгүүлэх гэрээг “Хүннү Эйр” ХХК-тай байгуулаад байна.</p>
2.114.7	Үндэсний агаарын тээвэрлэгчийн менежментийг концессоор гүйцэтгүүлэх замаар бүтэц, менежментийг шинэчлэх /Үндэсний агаарын тээвэрлэгчийн менежментийг концессоор гүйцэтгүүлэх шийдвэр гаргуулах/	<p>“Судалгаа, танилцуулга, Засгийн газрын тогтоолын төслийг бэлтгэн 2016.01.20-ны 01/221 дугаар албан бичгийг яамдаас санал авсан. Яамдаас ирүүлсэн саналыг нэгтгэн саналын товчоо бэлтгэж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхэд бэлэн болгосон.</p> <p>Засгийн газрын бүтэц, зохион байгуулалт, зарим яам, агентлагийн чиг үүрэг шинэчлэгдсэнтэй холбоотойгоор МИАТ ТӨХК-ийн менежментийг концессоор хэрэгжүүлэх ажлыг Засгийн газрын 2013 оны 317 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт”-д нэмэлтээр оруулах асуудлыг хуулиар олгогдсон бүрэн эрхийнхээ хүрээнд шийдвэрлүүлж өгөхийг хүсч, ЗТХ-ийн сайдын 2016 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн 01/2003 тоот албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт шилжүүлсэн.</p>
2.114.15	Чингис Хаан	ЗТХ-ийн сайдын 2016 оны 70 дугаар тушаалаар баталсан ИНЕГ-ын

	<p>ОУНБ-ын үйл ажиллагааг шинэ нисэх буудалд шилжүүлэх, шинэ нисэх буудлын үйл ажиллагааг тогтворжуулах /Олон улсын шинэ нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх/</p>	<p>бүтцэд Олон улсын шинэ нисэх буудлыг ашиглалтад оруулах бэлтгэл ажлыг хангах ашиглалтын өмнөх захиргааны албыг байгуулсан. Ашиглалтын өмнөх захиргааны алба нь “Чингис Хаан” ОУНБ-ыг нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах төлөвлөгөөг Японы консорциумтай хамтран шинэчлэн боловсруулж, ЗТХЯ-ны ТНБД-аар ахлуулсан ажлын хэсэгт 2017 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр танилцуулсан. Шинэ нисэх буудлын үйл ажиллагааг эрхлэн явуулах компанийн үйл ажиллагаанд шаардлагатай эхлэлтийн хөрөнгө оруулалт, “Чингис хаан” Олон улсын нисэх буудал болон Газрын тусгай үйлчилгээний албанаас шилжиж ирэх хөрөнгийн жагсаалтыг гарган, ИНЕГ-ын удирдлагуудад танилцуулсан. ИНЕГ-ын даргын 2017 оны А/202 дугаар тушаалаар хил, гааль, агаарын тээвэрлэгч болон бусад холбогдох байгууллагуудын оролцоотой нүүлгэн шилжүүлэх бэлтгэл ажлыг хангах, хамтран зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсгийн 2017 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний төслийг танилцуулж, хилийн хяналтын болон агаарын тээврийн байгууллага тус бүр өөрсдийн үйл ажиллагааг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөг боловсруулж, батлуулах шийдвэр гаргасны дагуу арга хэмжээ авч ажиллаж байна. Хилийн хяналтын болон агаарын тээврийн байгууллага 8 удаагийн уулзалт зохион байгуулж, шинэ нисэх буудлын төлөвлөлт, зохион байгуулалтын мэдээллээр хангаж, хамтран ажиллаж байна. “Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл”-ийг хэрэгжүүлэх санал тавьсан Японы консорциумтай хэлэлцээ хийх шатанд байгаа бөгөөд МУ-ын Засгийн газар болон ЯУ-ын хувийн хэвшил хоорондын харилцан тохиролцоо шаардлагатай асуудлуудыг шийдвэрлэсний дараа концессын гэрээг байгуулах бөгөөд тухайн өдрөөс хойш 12 сарын бэлтгэл ажлыг хэрэгжүүлснээр шинэ нисэх буудлын нислэг үйлдвэрлэлийн үйл ажиллагааг эхлүүлэх тул “Чингис Хаан” ОУНБ-ыг нүүлгэн шилжүүлэх өдөр одоогоор тодорхойгүй байна.</p>
<p>2.121.3</p>	<p>Дархан-Эрдэнэт, Улаанбаатар-Арвайхээр, Улаанбаатар-Чингис, Налайх-Чойр, Хархорин-Цэцэрлэг, Улаангом-Хандгайт, Өлгий-Улаан байшинт чиглэлийн 725 км авто замд ээлжит засварын ажлыг гүйцэтгэх /181 км авто замд ээлжит засварын ажлыг хийж гүйцэтгэх/</p>	<p>2017 оны улсын төсвийн төсөлд УБ-Арвайхээр чиглэлийн 62 км, УБ-Чойр чиглэлийн 59 км, УБ-Дархан чиглэлийн 64 км авто замд ээлжит засвар хийх санал хүргүүлсэн боловч хөрөнгө шийдэгдээгүй.</p> <p>Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн Улаанбаатар-Дархан А0401 чиглэлийн авто замын 196-202 дахь км буюу 6 км авто замын ээлжит засварын ажлыг “Дархан АЗЗА” ТӨХК гүйцэтгэж, 2017 оны 08 дугаар сарын 09-ний өдөр ашиглалтад хүлээлгэн өгсөн.</p>
<p>6.14.2.2</p>	<p>Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Шар тээг-Цогтэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто замыг үргэлжлүүлж дуусгах</p> <p>/Ажлын гүйцэтгэлийг 33 хувьд хүргэх/</p>	<p>Өмнөговь аймгийн Даланзадгад сумын Шар тээг-Цогтэций сумын төв хүртэлх 59.6 км хатуу хучилттай авто замын төслийг концессын “Барих-шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлэх гэрээг “Эн Си Эф” ХХК-тай байгуулсан. Одоогоор концесс эзэмшигч гэрээ хүчин төгөлдөр болох нөхцөлүүдийг хангахаар ажиллаж байна. Үндэсний хөгжлийн газраас Концессын гэрээ хүчин төгөлдөр болж, зам барилгын ажилд өдөр тутмын хяналт тавих Зөвлөх компани сонгон гэрээ байгуулсан тохиолдолд зам барилгын ажлыг эхлүүлэх нөхцөл бүрдэнэ.</p>

<p>Аймаг, орон нутагт хэрэгжүүлэх дараах 17 арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр одоогоор тодорхойгүй байна.</p>	
<p>6.1.1.1</p>	<p>Мянганы замын хэвтээ тэнхлэгийн Орхон гол-Их тамир чиглэлийн гүүр замыг гүйцээж Мянганы замд холбох /139 км хатуу хучилттай авто зам, гүүрийг шинээр барих/</p>
<p>6.2.1.1</p>	<p>Өлгий хотын Нисэх буудлын хатуу хучилттай зурвасыг өргөтгөж, хүнд даацын том онгоц хүлээж авах боломжийг бүрдүүлэх</p>
<p>6.4.1.1</p>	<p>Хялганат-Хангал-Эрдэнэт чиглэлийн хатуу хучилттай авто замын ажлыг хийж гүйцэтгэх</p>
<p>6.7.1.1</p>	<p>Дархан-Шарын гол чиглэлийн 48 км авто зам, авто замын байгууламжийг эхлүүлэх</p>
<p>6.8.1.1</p>	<p>Сайншанд-Хамарын хийд чиглэлийн авто замын уулзвараас Зүүнбаян баг хүртэлх 16 км хатуу хучилттай авто замыг барих</p>



6.9.1.1	Чойбалсан хотоос Хавирга хилийн боомт чиглэлд 124.5 км хатуу хучилттай авто зам барих	
6.9.1.2	Чойбалсан сумаас Эрэнцав боомт чиглэлд 200 км хатуу хучилттай авто зам барих	
6.9.1.3	Чойбалсан хотоос Баянхошуу хилийн боомт /Халхгол сум/ чиглэлд 323 км хатуу хучилттай авто зам барих	
6.9.1.4	Чойбалсан хотоос Ульхан хилийн боомт чиглэлд 233.48 км хатуу хучилттай авто зам барих	
6.13.1.1	Хужирт-Төвхөн хийд-Улаан цутгалан, Хархорин-Хужирт-Арвайхээр чиглэлийн авто замыг шинээр барих	
6.16.1.1	Улаанбаатар-Алтанбулаг чиглэлийн олон улсын авто замаас Шаамар, Зүүнбүрэн, Цагааннуур, Түшиг чиглэлийн 112 км авто зам барих	МУ-ын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 63 дугаар тэмдэглэлээр эдийн засгийн хүндрэлтэй байгаа нөхцөл байдалтай уялдуулан төсөвт ирэх ачааллыг бууруулах зорилгоор улсын хөгжлийн төлөвлөлттэй нийцээгүй, нийгэм эдийн засгийн ач холбогдол багатай концессын гэрээ байгуулсан боловч барилга угсралтын ажил эхлээгүй Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 112 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг хийж гүйцэтгэх хугацааг түр хойшлуулахаар шийдвэрлэсэн.
6.16.1.2	Дархан-Эрдэнэтийн чиглэлийн замаас Орхонтуул сумын төв хүртэл 65 км хатуу хучилттай авто зам барих	
6.16.1.3	Дархан-Улаанбаатарын чиглэлийн авто замаас Мандал сумын төв хүртэл 32 км хатуу хучилттай авто зам барих	
6.16.1.6	Аймгийн төв Сүхбаатар сумын ерөнхий төлөвлөгөөний дагуу төв дотор 34 км хатуу хучилттай авто зам барих	
6.16.1.7	Сумдын төвийн хатуу хучилттай авто замын сүлжээг нэмэгдүүлэх	
6.19.1.1	Чоно харайхын гүүрийг ашиглалтад оруулах /Дөргөн сум/	
6.21.1.1	Даланжаргалан сумаас Бор-Өндөр чиглэлийн 45 км хатуу хучилттай зам барих	Концессын гэрээгээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд гүйцэтгүүлэх концессын зүйлийн жагсаалтад тусгагдсан Даланжаргалан сумаас Бор-Өндөр чиглэлийн 45 км хатуу хучилттай замыг Эдийн засгийн хүндрэлтэй байгаа нөхцөл байдалтай уялдуулан төсөвт ирэх ачааллыг бууруулах зорилгоор улсын хөгжлийн төлөвлөлттэй нийцээгүй, нийгэм эдийн засгийн ач холбогдол багатай тул одоогоор хэрэгжүүлж эхлээгүй байна. Мөн цаашид концессын “барих-шилжүүлэх” төрлөөр авто замын төслийг хэрэгжүүлэхгүй гэсэн чиглэлийг УИХ-аас гаргасан. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгуулахаар 2017.08.15-ны өдрийн 01/3569 тоот албан бичгээр Сангийн яаманд санал хүргүүлсэн боловч 2018 оны улсын төсвийн тухай хуульд тусгагдаагүй.

40 хувийн биелэлттэй дараах 11 арга хэмжээг эрчимжүүлэх шаардлагатай гэж үнэллээ. Үүнд:

Хүснэгт 6

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Хэрэгжилт
2.107.15	Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замыг барих /Барилгын ажлыг дуусгах/	Захиалагч 2016 оны 12 дугаар сард тус авто замын барилгын ажлын гэрээг дүгнэн хөрөнгийн эх үүсвэр өөрчлөгдөж байгаатай холбогдуулан гэрээг дуусгавар болгосон. Барилгын ажил 60%-тай байна. Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км авто замын барилгын ажлын үлдэгдэл хөрөнгийг БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хэмнэлтийн хөрөнгөөс шийдвэрлүүлэх асуудлыг Хятадын талтай хэлэлцэж, танилцуулахыг Засгийн газрын 2016.08.31-ны өдрийн 44 дүгээр тэмдэглэлээр Сангийн сайдад үүрэг болгосон. Засгийн газрын 2017 оны 132 дугаар тогтоолоор БНХАУ-ын Засгийн газраас МУ-ын Засгийн газарт олгосон 500.0 сая долларын экспортын зээлээс авто замын салбарт хуваарилагдсан хөрөнгийн хэмнэгдсэн 24 сая ам.долларын эх үүсвэрээр Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто замын үлдэгдэл барилгын ажлыг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн. Уг тогтоолын дагуу Сангийн яамнаас БНХАУ-ын Засгийн газарт санал хүргүүлж Экзим банктай тохиролцсон. Сангийн яамнаас 2017.09.13-ны өдөр ирүүлсэн албан тоотын дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлан 2017.10.02-ны өдөр нээж, үнэлгээний хорооны дүгнэлт, зөвлөмжийг тус яамны ТНБД-д танилцуулсан. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”-ийн 30 дугаар зүйлийн 30.1.3 дахь

		<p>заалтад “шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн тохиолдолд захиалагч бүх тендерээс татгалзана” гэж заасныг үндэслэн бүх тендерээс татгалзаж, мэдэгдлийг тендерт оролцогчдод хүрүүлсэн. Дахин хязгаарлагдмал тендер шалгаруулалт явуулахаар тендерийн үнийн санал ирүүлэх урилгыг 2017.11.03-ны өдөр тутмын сонинд зарлан 2017.11.20-ны өдөр нээж, үнэлгээний хорооны дүгнэлтийг ТНБД-д 2018.11.24-ний өдөр танилцуулсан. Зөвлөмжийн дагуу шууд гэрээ байгуулах ажлын хүрээнд тендерт оролцогч аж ахуйн нэгжтэй үнийн хэлэлцээ хийхээр мэдэгдлийг хүргүүлээд байна. Хамгийн бага үнийн санал өгсөн “Чайна рейлвэй ферст групп” компанитай гэрээний хэлэлцээ хийж байна.</p>
2.109.2	<p>“Шивээхүрэн-Сэхэ” боомтын төмөр замыг барих</p> <p>/Барилгын ажлыг дуусгах/</p>	<p>Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын шугамын чигийг тогтоох Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, Засгийн газрын 2017 оны 126 дугаар тогтоолоор батлуулсан.</p> <p>“Монголын Алт” ХХК-ийн захиалгаар 2008 онд Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын ТЭЗҮ-ийг БНХАУ-ын Зураг төслийн 3 дугаар хүрээлэн боловсруулсныг тус компани “Мөнгөн зөрлөг” ХХК-тай 2017 оны 05 дугаар сард гэрээ байгуулан ТЭЗҮ, зураг төслийг шинэчлүүлсэн.</p> <p>Тус чиглэлийн царигийн өргөний хэмжээг тогтоох тухай УИХ-ын тогтоолын төсөл, үзэл баримтлалын төсөл боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн дэмжүүлж, Засгийн газрын 2017 оны 35 дугаар хуралдааны тэмдэглэлээр УИХ-д өргөн барихаар тогтсон.</p> <p>Гэвч Засгийн газар эмхлэн байгуулагдсантай холбогдон Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасан баримт бичгийг шинэчлэн ирүүлэх чиглэл өгсөн. Үүний дагуу УИХ-ын тогтоолын төслийн үзэл баримтлалын төслийг шинэчлэн, УИХ-ын намрын чуулганаар хэлэлцүүлэхээр ажиллаж байна.</p> <p>Тус чиглэлийн төмөр замын барилгын ажилд шаардлагатай санхүүжилтийн асуудлыг тухайн бүс нутагт уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгч нартай хамтарч шийдвэрлэхээр ажиллаж байна.</p>
2.111.3	<p>“Богдхан” төмөр замын трассыг баталж, ТЭЗҮ-ийг боловсруулан барилгын ажлыг эхлүүлэх</p> <p>/ТЭЗҮ, зураг төслийг боловсруулах/</p>	<p>Богдхан төмөр замын төслийг хэрэгжүүлэхээр ЗТЯ болон АХБ хооронд 2014 онд Харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсны дагуу АХБ-наас үзүүлж буй техникийн туслалцаагаар “Ай Си Ти Интернэшнл” ХХК тэргүүтэй зөвлөх компани “УБТЗ” ХНН-ийн Мандал өртөөнөөс Багахангай чиглэлд шинээр барих “Богдхан” төмөр зам төслийн чигийн судалгааг боловсруулсан.</p> <p>Зөвлөх компани “Богдхан” төмөр замын чигийн 5 хувилбарыг 2017 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр ЗТХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж, улмаар 5 дахь чигийн хувилбарыг дэмжиж, координат болон солбицлыг ЗГ-ын хуралдаанаар батлуулах шийдвэр гарсан. Зөвлөх компани чигийн судалгааны эцсийн тайланг 2017 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр ЗТХЯ-нд хүлээлгэж өгсөн.</p> <p>Тус төмөр замын чигийг ЗГ-ын хуралдаанаар батлуулж, ТЭЗҮ, зураг төслийг боловсруулахаар ажиллаж байна.</p>
2.114.11	<p>Дорнод аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, агаарын хөлөг хүлээн авах 4С хүчин чадалтай болгох</p> <p>/Санхүүжилтийг шийдвэрлүүлэх зураг төсөл, ТЭЗҮ батлагдах/</p>	<p>Дорнод аймаг дахь “Чойбалсан” нисэх буудлыг өргөтгөн шинэчилж, 4С болгох зураг төсөл хийлгэхэд 250 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай бөгөөд ИНЕГ-ын 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд зураг төслийн санхүүжилтыг тусгуулахаар саналыг ИНЕГ-ын Худалдан авах ажиллагааны хэлтэст хүргүүлсэн.</p> <p>Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээрийн төсөлд буудлын өргөтгөлийн ажлыг тусгуулахаар саналаа Зам, тээврийн сайдын 2016 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 01/1883 тоот албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>ИНЕГ-аас ОХУ-аас авах зээлийн хөрөнгөөр хийх ажлын жагсаалтад Чойбалсан нисэх буудлыг хамруулах санал ирүүлснийг Хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн хэлтэс хянаж байна.</p> <p>Тус нисэх буудлыг өргөтгөх зураг төсөв боловсруулах зардал, барилгын ажлын санхүүжилтийг БНСУ-ын “Эксим” банкны зээлээр санхүүжүүлэхээр санал боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн.</p>
2.114.12	<p>Өмнөговь аймаг дахь</p>	<p>Даланзадгад дахь нисэх онгоцны буудлыг олон улсын зэрэглэлтэй буудал болгон шинэчлэн барих төсөл концессын зүйлийн жагсаалт батлах тухай</p>

	<p>нисэх буудлыг 4D ангиллын, олон улсын нөөц нисэх буудал болгох</p> <p>/Санхүүжилтийг шийдвэрлүүлэх зураг төсөл, ТЭЗҮ батлагдах/</p>	<p>ЗГ-ын 2013 оны 317 дугаар тогтоолоор батлагдсан. Өмнөговь аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх, 4D ангиллын хүчин чадалтай, Олон улсын нөөц нисэх буудал болгох ажлыг Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах саналыг ЗТХС-ын 2017 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 01/1968 тоот албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт хүргүүлсэн. Өмнөговь аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх, 4D ангиллын хүчин чадалтай олон улсын нөөц нисэх буудал болгох зураг төсөв боловсруулах зардал, барилгын ажлын санхүүжилтийг “Эксим” банкны зээлээр санхүүжүүлэхээр санал боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн. Өмнөговь аймгийн нисэх буудлыг өргөтгөн шинэчлэх, 4D ангиллын хүчин чадалтай олон улсын нөөц нисэх буудал болгох зураг төсөв боловсруулах зардал, барилгын ажлын санхүүжилтийг “Эксим” банкны зээлээр санхүүжүүлэхээр санал боловсруулан Сангийн яаманд хүргүүлсэн. ЗТХ-ийн сайдын 2017 оны 137 дугаар тушаалаар батлагдсан “Иргэний нисэхийн ерөнхий газрын 2016 оны үйл ажиллагааны цэвэр ашгийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалт”-д Өмнөговь аймаг дахь нисэх буудлын зорчигч үйлчилгээний барилга байгууламжийн зураг төсөл боловсруулахад 60 сая төгрөг тусгасан. Зураг төслийг хийх компаниудын дэлгэрэнгүй жагсаалтыг 2017.10.20-нд гаргасан. 2017.11.15-нд хураангуй жагсаалт гаргаж, тендерийн саналын урилга, ажлын даалгаврыг тендерт оролцогчдод хүргүүлсэн. 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдөр тендер нээсэн, үнэлгээ хийж байна.</p>
2.115.2	<p>Ерөнхий зориулалтын нисэхийн олон улсын стандартыг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх</p> <p>/Хелипортын стандарт, дэд бүтцийг хөгжүүлэх дэд хөтөлбөр батлагдах/</p>	<p>Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-ын Хавсралт 14-ын 2-р хэсэг, АНУ-д мөрдөгдөж буй стандартуудыг орчуулсан. Мөн хелипортын стандартын төслийг боловсруулж, 2017 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээс гаргасан саналуудыг тусган шинэчлэн боловсруулж, батлуулахад бэлтгэж байна.</p>
2.116.1	<p>Монгол-Орос-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрт тусгагдсан тээврийн салбарын төсөл, арга хэмжээг судалж хэрэгжүүлэх</p> <p>/Төсөл, арга хэмжээг нэг бүрчлэн судлах судалгааны ажлыг хийж эхлэх/</p>	<p>“Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай” Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн хүрээнд “Хөгжлийн зам-Тээвэр, логистикийн хамтын ажиллагаа” сэдэвт олон улсын бага хурлыг УБ хотноо 2017 оны 10 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд зохион байгуулахаар ажиллаж байна. Бага хурлын бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Зам, тээврийн хөгжлийн сайдын 2017 оны 52 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна. “Орос-Монгол-Хятадын эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн төслийн жагсаалт”-ын 12 дугаарт туссан “Азийн авто замын сүлжээгээр олон улсын автотээвэрлэлт гүйцэтгэх тухай ОХУ, МУ, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулсан.</p>
2.119.3	<p>Гачууртын уулзвараас Налайх-Чойрын уулзвар хүртэлх 20.9 км авто замд өргөтгөл, шинэчлэл хийх</p> <p>/Барилгын ажлын гүйцэтгэл 10 хувь/</p>	<p>Тус төслийг Засгийн газрын 2015 оны 458 тогтоолоор төслийн ажлыг зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр шийдвэрлэсний дагуу төслийн гүйцэтгэгч “Синохайдро корпораци лимитед” компанитай 2016 оны 09 дүгээр сарын 09-ний өдөр барилгын ажлын гэрээ, 2017 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр “Гуанжоу Ванан Констракшн Супервишн” ХХК-тай зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан. /Төслийн нийт өртөг 38,2 сая ам.доллар. Хэрэгжүүлэх хугацаа 24 сар/</p> <p>Захиалагчийн зүгээс Баянзүрхийн товчоо орчмын газар чөлөөлөлтийн нөлөөлөл ихтэй авто замын трассыг өөрчлөхөөр шийдвэрлэсний дагуу зургийн зөвлөх компани замын трассын эхний 5км-т өөрчлөлт оруулан зураг төслийг боловсруулж дууссан.</p> <p>Авто замын трасст өөрчлөлт оруулснаар нөлөөлөлд өртсөн 219 иргэн, ААН, байгууллагын эзэмшил, өмчлөлийн нэгж талбарыг 82 болгон багасгаж, 57807м² талбай нөлөөллөөс хасагдаж, нийт газар чөлөөлөлтийн ажлыг 137 нэгж талбараар буюу 45%-иар багасгасан. Анх тооцоолсон нөхөн олговрын зардлыг 7,527,051,129.00 төгрөгөөс эрс бууруулж, Нийслэлийн ЗД-ын 2017 оны А/651, А/675, А/691 дугаар захирамжуудаар нийт 1,181,885,456.00 төгрөг олгож, Нийслэлийн Газрын албанаас 09 дүгээр сарын 25-ны өдөр төслийн газар чөлөөлөлтийн ажлыг бүрэн хэрэгжүүлж дууссан.</p>

		<p>Нийслэлийн ЗД-ын 2017 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн А/617 захирамжаар 3 байршилд авто замын барилгын ажилд ашиглах карьерын зөвшөөрөл олгосон.</p> <p>ЗГ-ын 2017 оны 222 дугаар тогтоолоор төслийн Монголын талын хариуцах зардал 15%-ийг 5% болгон өөрчлөн баталсан.</p> <p>Төслийн газар чөлөөлөлтийн ажил дууссан талаарх Нийслэлийн Газрын албаны албан бичиг, газар чөлөөлөлтийн ажлын тайлан болон авто замын байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт, тэдгээрийн орчуулгыг Сангийн яаманд хүргүүлсэн. Төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг боловсруулж, БОАЖЯ-нд хүргүүлсэн.</p> <p>Хятадын Эксим банк, Сангийн яам хооронд тусгайлсан зээлийн гэрээ байгуулах бэлтгэл ажил хийгдэж байна.</p>
5.1.3.1	<p>Зам, тээврийн салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай уялдуулан шинэчлэх, шинээр боловсруулах дэд салбарын талаар төрөөс баримтлах бодлогыг шинэчлэх</p> <p>/Салбарын хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрүүдэд шинэчлэл хийж, баримт бичиг батлагдах/</p>	<p>“Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д нийцсэн эсэхийг хянах, бодлогын баримт бичгийг шинээр болон шинэчлэн боловсруулах тухай ЗТХ-ийн сайдын 2017 оны 36 дугаар тушаалаар Зам, тээврийн салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг батласан.</p> <p>- Төрөөс авто замын талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулах ажлын төлөвлөгөөг боловсруулан, 2017 оны 02 дугаар сарын 24-ний өдөр ТНБД-аар батлуулж, ЗТХ-ийн сайдын 2017 оны 59 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулсан. Авто замын салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн суурь судалгааны ажилд 30.0 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, зам, тээврийн салбарын норм нормативын сангийн 2017-2018 оны төлөвлөгөөнд тусгасан. Авто замын салбарт төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн бодлогын судалгааны ажлын даалгаврыг боловсруулж ТНБД-аар батлуулсан.</p> <p>Зөвлөх үйлчилгээний тендерт шалгарсан “Хязгааргүй хөдөлгөөн” ХХК-тай 2017 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 272 дугаар гэрээг байгуулан, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллаж байна. Мөн ажлын хэсгийн хүрээнд бодлогын баримт бичгийг боловсруулахтай холбогдох баримт бичгүүдийг судлан, баримт бичгийн хамрах хүрээ, агуулгын төслийг боловсруулсан. Судалгааны ажлын үр дүнгээр бодлогын баримт бичгийн төслийн эцсийн хувилбарыг боловсруулна.</p> <p>- Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг 2017.06.07-ны өдөр байгуулсан. Ажлын хэсгийг БТГ-ын дарга ахалж, баримт бичгийг боловсруулах ажил хийгдэж байна. Ажлын хэсэг 2017 оны 08 дугаар сарын 21-ний өдөр хуралдаж ажлын хэсгийн ажлын зохион байгуулалт болон төслийн эхний хэлэлцүүлгийг хийсэн. Ажлын хэсгийн гишүүдэд тус бодлогын бичиг баримт дээр санал боловсруулах чиглэл өгөөд ажиллаж байна.</p> <p>- Төрөөс автотээврийн салбарт баримтлах бодлогын баримт бичгийн төслийг боловсруулж, 2017 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дэмжигдсэн. Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбогдуулан Автотээврийн талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийг Сайдын зөвлөлийн хуралдаанаар дахин оруулахаар бэлтгэж байна.</p> <p>- Төрөөс иргэний нисэхийн салбарт 2020 он хүртэл баримтлах бодлого”-д нэмэлт өөрчлөлт оруулах төслийг боловсруулсан. Бодлогын 2016 оны хэрэгжилтийн байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, нэмэлт, өөрчлөлт оруулах дүгнэлт гарсан. Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу холбогдох судалгаа, шинжилгээ, шаардагдах санхүүжилт зэрэг хавсралт баримт бичгийг бүрдүүлэх шатанд байна. Иргэний нисэхийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй уялдуулан бодлогод оруулах нэмэлт, өөрчлөлтийг тусган, хамтад нь 2018 онд батлуулахаар хойшлуулснаар энэ онд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтаас хасагдсан.</p>
5.6.5.1	Гуравдагч улсаас БНХАУ-ын нутаг дэвсгэрээр	Гуравдагч улсаас БНХАУ-ын нутаг дэвсгэрээр дамжин Монгол Улсад импортлогдож буй бараа, бүтээгдэхүүний тарифын болон тарифын бус хориг саадыг арилгах зорилгоор далайд гарцгүй орны хувьд Монгол Улс нь Хуурай боомтын талаарх Засгийн газар хоорондын хэлэлцээрт нэгдэн орсон болно. Монгол Улсад хуурай боомтыг хөгжүүлэх, байгуулах талаар

	<p>дамжин Монгол Улсад импортлогдож буй бараа, бүтээгдэхүүний тарифын болон тарифыг бус хориг саадыг арилгахад чиглэгдсэн үйл ажиллагааг шат дараалалтайгаар зохион байгуулах</p> <p>/Хориг саадыг арилгах чиглэлээр ажиллаж, тодорхой ахиц гаргах/</p>	<p>хуурай боомтыг байгуулах үндсэн зарчим, байгуулснаар гарах үр нөлөө, ач холбогдол, цаашид авах шаардлагатай арга хэмжээний талаар танилцуулга бэлдсэн. Мөн хуурай боомт байгуулан ажиллахад эрх зүйн орчны зохицуулалтыг хэрхэн хийж байгаа талаар судалгаа, Замын-Үүдийн тээвэр логистикийн төвд хуурай боомт байгуулах боломж зэргийг судалж байна. Гаалийн тарифын зөвлөлийн хуралдааны 2017 онд хэлэлцүүлэх асуудлын төлөвлөгөөнд дараах саналыг СЯ-нд хүргүүлсэн. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Монгол Улсад угсарч, үйлдвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн зарим эд анги, сэлбэг, хэрэгслийг импортын татвараас чөлөөлөх тухай асуудлыг танилцуулах; - Иргэний агаарын хөлөгт ашиглах зорилгоор Цагааннуур боомтоор импортлох агаарын хөлгийн шатахууны гаалийн болон онцгой албан татварыг чөлөөлөх асуудлыг танилцуулах; - Монгол Зөвлөлтийн хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг байгуулах тухай 1949 оны Монгол, Оросын Засгийн газар хоорондын хэлэлцээрээр Монголын талын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх талаарх саналыг хэлэлцүүлэх. <p>МУ-ын Ерөнхий сайд БНХАУ-ын Бээжин хотноо зохион байгуулагдсан “НЭГ БҮС-НЭГ ЗАМ” олон улсын хамтын ажиллагааны дээд хэмжээний уулзалтад оролцох үеэр хийгдэх ярианы сэдэвт энэхүү асуудлаар дараах саналуудыг ГХЯ-нд хүргүүлэн ярианы сэдэвт тусгуулсан болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - “Монгол-Орос-Хятадын Гаалийн байгууллагууд хоорондын хэлэлцээр”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах, мэдээлэл солилцох хэлбэр, хэлэлцээр үйлчлэх хилийн боомтууд, оролцогчид, гаалийн хяналтын үзлэгийг нь харилцан зөвшөөрөх зарим барааны нэр төрлийг тохиролцох; - Монгол, Хятад, Оросын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрдөг төмөр замын төв коридорын ашиглалтыг сайжруулах ажлын хүрээнд төмөр замын тээврийн хөлсөнд харилцан хөнгөлөлт үзүүлэх талаар тохиролцох, Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулах санал дэвшүүлэх; - Эрээн боомтоор импортоор хүлээн авдаг бараа бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлж, Замын-Үүд-Эрээн боомтын хамтын ажиллагааг өргөжүүлэх. Тухайлбал: Эрээн боомтоор шинэ автомашин оруулдаг болгох, автомашин, мод модон эдлэлийн гүний гаалийн бүрдүүлэлтийг хийхийг зөвшөөрдөг болгох. <p>Монголын тээвэр зуучийн нэгдсэн холбоо, Туушин, Монгол транс, Монгол-Экспресс, “МТЗНХ” ТББ, зэрэг тээвэр зуучийн компанийн төлөөлөлтэй Сайдын зөвлөх, БТГ, ТЗДТБХЗГ-ын дарга, холбогдох мэргэжилтэн Хуурай боомтын талаар уулзалт, хэлэлцүүлгийг 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулж, Хуурай боомтын талаар судалгаа хийх үүрэг бүхий ажлын хэсгийг хамтран байгуулахаар шийдвэрлэсэн. Уг ажлын хэсгийн хүрээнд Хуурай боомтыг хөгжүүлэх, импортлогдож буй бараа, бүтээгдэхүүний тарифын болон тарифыг бус хориг саадыг арилгахад чиглэгдсэн судалгааг хийхээр тохиролцоод байна.</p> <p>Тайландын Вант Улсын Бангкок хотноо 2017 оны 11 дүгээр сарын 13-16-ны өдрүүдэд болсон “Хуурай боомтын ажлын хэсэг”-ийн 2 дугаар уулзалтыг зохион байгуулсан.</p> <p>Уулзалтын үеэр Монгол Улс дахь хуурай боомтын өнөөгийн байдал, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар танилцуулга хийж Монгол Улс, ОХУ, БНХАУ-ын Эдийн засгийн коридор байгуулах хөтөлбөрийн хэрэгжилтэд хуурай боомтын гүйцэтгэх үүрэг чухал зэргийг онцолж, Монгол Улсад хуурай боомт байгуулахад эрх зүйн зохицуулалтын хувьд НҮБ-ын АНДЭЗК-оос Техникийн туслалцаа авах хүсэлтэй байгаагаа уламжилсныг Ажлын хэсгийн илтгэлд албан ёсоор тусгасан.</p>
<p>5.3.1.1</p>	<p>1.Баянхонгор-Бууцагаан чиглэлийн авто замыг барьж ашиглалтад оруулах</p>	<p>“БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжих Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр БНХАУ-ын “Шанхай Констракшн Групп” ХХК шалгарч 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр нийт 56,785,696.10 ам.долларын ажил гүйцэтгэх гэрээг тус яамтай байгуулсан. Зураг зохиогч авто замын трассын улаан шугамыг гүйцэтгэгч болон зөвлөхөд 2016 оны 09 дүгээр сарын 07-ны өдөр хүлээлгэж өгсөн бөгөөд гүйцэтгэгч компани 2016 онд авто замын барилгын бэлтгэл ажлыг хангах хүрээнд нүүлгэн шилжүүлэлт, кэмп</p>

/Авто замын ажлын 80 хувийг гүйцэтгэх/	<p>байгуулах, хэмжилтийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн. 2017 онд барилгын ажилд шаардлагатай гадаадаас авах 280 ажиллах хүчний асуудлыг Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн 99 дүгээр тогтоолоор шийдвэрлүүлсэн. Батлагдсан график төлөвлөгөөний дагуу 2017 оны барилга угсралтын ажлыг 05 сарын 10-ны өдөр эхлүүлсэн бөгөөд хөрс хуулалт 100%, далангийн дүүргэлт 96%, суурийн ажил 20%, гүүрийн ажил 28%, хиймэл байгууламжийн ажил 61% тус тус хийгдээд байна. Нийт ажлын явц 39.07%-тай байна.</p> <p>Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замыг барих шилжүүлэх нөхцөлтэйгээр “Эрчим хүчний барилга угсралтын трест” ХХК-тай 2015 оны 06 дугаар сарын 05-ны өдөр концессын гэрээ байгуулсан барилгын ажлыг эхлүүлсэн. Гүйцэтгэгч компани нь 2015 онд уг замын трасс сэргээх, хөрс хуулах зэрэг бэлтгэл ажлыг хийж гүйцэтгэсэн бөгөөд одоогоор нийт ажлын явц 5%-тай байна. Гэрээний дагуу уг авто замыг 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдөр ашиглалтад оруулахаар ажиллаж байсан хэдий ч өмнө нь гэрээ байгуулж байсан “Эрдэнэ зам” ХХК-ийн зүгээс нэхэмжлэл гаргаж МУ-ын Засгийн газрыг шүүхэд өгснөөр төслийн ажлыг шүүхээс түр зогсоогоод байна. МУ-ын Засгийн газрын 2016 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 63 дугаар тэмдэглэлээр барилга угсралтын ажил нь шүүхийн маргааны улмаас түр зогссон аймгийн төвийг нийслэлтэй холбох зорилтын хүрээнд хэрэгжиж буй Байдрагийн гүүр-Алтай чиглэлийн 126.7 км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг гүйцэтгүүлэх концессын гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцуулах тухай шүүхийн маргаан шийдвэрлэгдсэний дараагаар хөрөнгийн өөр эх үүсвэрээс төслийг хэрэгжүүлэх талаар зохих арга хэмжээг авахаар шийдвэрлэсэн. Засгийн газрын 2017.03.20-ны өдрийн хуралдааны 13-р тэмдэглэлээр Баянхонгор-Алтай чиглэлийн 126.7 км авто замын барилгын ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан аж ахуйн нэгжтэй үүссэн шүүхийн маргааныг эцэслэн шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг сайд Д.Ганбатад, тус авто замын төслийн ажлыг шууд гэрээ байгуулан эхлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг ҮХГ-ын дарга Б.Баярсайханд даалгасан. Өгсөн үүрэг даалгаврын дагуу “Эрдэнэ зам” ХХК болон “Эрчим хүчний барилга угсралтын тресс” ХХК-уудын удирдлагуудтай уулзалт зохион байгуулж саналыг нь авсан. Уулзалтаар тохиролцсоны дагуу ТНБД-ын 2017.06.02-ны өдрийн 164 дүгээр тушаалаар тус чиглэлийн замд хийгдсэн ажлын тоо хэмжээг тодорхойлж, дүгнэлт гаргах ажлын хэсэг байгуулсан. Ажлын хэсэг 2017.06.06-2017.06.10-ны өдөр хүртэл зам барилгын ажлын талбайд ажиллаж, хэмжилт хийсэн. 2017.06.12-ны өдөр ЗТХЯ-ны 403 тоотод ажлын хэсэг хуралдаж, дүгнэлтийг 2017 оны 03/2674 тоот албан бичгээр Үндэсний хөгжлийн газарт, 06/2675 тоот албан бичгээр “Эрчим хүчний барилга угсралтын трест” ХХК болон “Аварга зам” ХХК-уудад тус тус хүргүүлсэн. “Эрдэнэ зам” ХХК шүүхээс нэхэмжлэлээ татан авснаар 2017 оны 06 дугаар сарын 27-ны өдөр Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 181/ШЗ2017/09403 захирамж гарч, шүүхийн маргаан дуусгавар болсон тул концесс эзэмшигч “Эрчим хүчний барилга угсралтын трест” ХХК-аас зам барилгын ажлаа үргэлжлүүлэх хүсэлт гаргасны дагуу Үндэсний хөгжлийн газраас концессын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах урьдчилсан нөхцөлүүдийг хангах үүрэг даалгавар өгсөн байна. Концесс эзэмшигчийн зүгээс урьдчилсан нөхцөл хангах ажил хийж байна.</p>
--	--

Дөрөв. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд 2017 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсний үндсэн дээр дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний жагсаалтыг Сайдын тушаалаар шинэчлэн батлуулахыг хоёрдугаар улирлын хяналт-шинжилгээ, үнэлгээний зөвлөмжөөр Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлсэн боловч одоо хүртэл шинэчлээгүй байгаа тул ачааллыг тэнцвэржүүлж, бодлогын чанартай болон хөрөнгийн асуудал шийдэгдээгүй төсөл арга хэмжээнүүдэд БТГ, шүүхийн маргаантай болон



эрх зүйн орчинг бий болох сайжруулах, хэлэлцээр хийх арга хэмжээнүүдэд ТЗУГ, хяналт шалгалт хийх болон ашиглалтад авах төсөл арга хэмжээнүүдэд ХШУДАГ-ыг хамтран хэрэгжүүлэхээр оруулах, мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын Засгийн газрын гишүүдтэй хамтран хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээг хариуцах газар, хэлтэс, байгууллагыг жагсаалтад тусгаж сайдын тушаалаар шинэчлэн батлуулахыг Бодлого, төлөвлөлтийн газарт;

2. Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд зорилт, арга хэмжээнүүдийн хүрэх түвшинг он тус бүрээр нь тодорхойлсон тул жилийн эцсийн байдлаар нийт арга хэмжээний хэрэгжилт 79.4%-тай, ялангуяа БТГ-ын хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт 76%-тай, АЗБХЗГ-ын хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт 74.8%-тай, АТБХЗГ-ын хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт 75%-тай, “МТЗ” ТӨХК-ийн хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт 62.5%-тай, Концесс эзэмшигч “Нортерн рейлвейс” ХХК-ийн хариуцан хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилт 70%-тай байгааг онцгой анхаарч, төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийг дуусах хугацаатай нь уялдуулан хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар зохион байгуулалт, зохицуулалтын арга хэмжээг эрчимтэй авч хэрэгжүүлэхийг харьяа байгууллагууд, яамны газар, хэлтсүүдэд;

3. Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.6-д “Бодлогын зорилт, арга хэмжээ, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2 удаагийн тайлангийн хугацаанд дараалан ахиц гараагүй бол УДААШИРСАН, 3 удаагийн тайлангийн хугацаанд мөн ахиц гараагүй бол ТАСАРСАН-д тооцно” гэж заасан тул Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 2018 онд үргэлжлүүлэн хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг 2017 оны хагас, бүтэн жилийн хэрэгжилтээс ахиулж, 2018 онд хүрэх түвшин, үр дүн, шалгуур үзүүлэлтэд хүргэхэд анхаарч ажиллахыг харьяа байгууллагууд, яамны газар, хэлтсүүдэд;

4. Хөрөнгийн асуудал шийдэгдээгүй, төсөвт өртгийн нэмэгдүүлэх шаардлагатай болон Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 63 дугаар тэмдэглэлээр эдийн засгийн хүндрэлтэй байгаа нөхцөл байдалтай уялдуулан төсөвт ирэх ачааллыг бууруулах зорилгоор улсын хөгжлийн төлөвлөлттэй нийцээгүй, нийгэм эдийн засгийн ач холбогдол багатай авто замын барилгын ажлыг хийж гүйцэтгэх хугацааг түр хойшлуулахаар шийдвэрлэсэн төсөл арга хэмжээнүүдийн талаар санал боловсруулж, ЗГХЭГ-т хүргүүлэн шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг Бодлого, төлөвлөлтийн газарт тус тус зөвлөж байна.

Танилцсан:

Сайд	Ж.Бат-Эрдэнэ
Дэд сайд	Б.Цогтгэрэл
Төрийн нарийн бичгийн дарга	Ж.Бат-Эрдэнэ
Төрийн захиргааны удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Б.Махбал
Бодлого, төлөвлөлтийн газрын дарга	Р.Мэргэн
Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга	Д.Доржханд



Авто тээврийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах газрын дарга С.Батболд

Төмөр зам, далайн тээврийн бодлогын
хэрэгжилтийг зохицуулах
газрын дарга Б.Артур

Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг
зохицуулах хэлтсийн дарга С.Мөнхнасан

Хянасан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын даргын үүргийг түр
орлон гүйцэтгэгч Т.Гомбосүрэн

Боловсруулсан:

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод
аудитын газрын ахлах мэргэжилтэн Н.Буянт